

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 05 дугаар  
Улаанбаатар  
сарын 09-ний өдөр

Дугаар...

хот

### **Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох, чөлөөлөх тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, 22.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Хаянгаагийн Болорчулуун, Эдийн засгийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Жамбалын Ганбаатар нарыг тус тус сонгосугай.

2. Монгол Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг, Төсвийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Баттогтохын Чойжилсүрэн нарыг тус тус улируулан сонгосугай.

3. Улсын Их Хурлын гишүүн Лхагваагийн Элдэв-Очирыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргын, Улсын Их Хурлын гишүүн Дорждамбын Дамба-Очирыг Эдийн засгийн байнгын хорооны даргын үүрэгт ажлаас тус тус чөлөөлсүгэй.

4. Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг